

Батсуурийн Анхбаяр^{1✉}, Басандоржийн Буян-Орших², Гончигийн Батболд¹,
Цэдэндоржийн Болорбат¹, Цэндийн Амгалантөгс¹,
Цао Жианэн³, Сүн Гүодүн, Цайси⁴, Цаофэн³

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

²Монголын үндэсний музей, Чингэлтэй дүүрэг,
Жуулчны гудамж-1, Улаанбаатар 15160, Монгол улс
³Өвөр Монголын Археологи, Соёлын өвийн хүрээлэн,
Сайхан дүүрэг, Үзэсгэлэнгийн ордны өмнөд замын 1-р байр,
Хөх хот 010010, Өвөр Монголын өөртөө засах орон, БНХАУ

⁴БНХАУ-ын Өвөр Монголын Багийн Их сургууль,
Шинжлэх ухаан, технологийн хүрээлэн,
Хөх хот, Сайхан дүүрэг, БНХАУ

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт буй хүн чулуудын тухай

Хураангуй: 2018, 2019 онд Монгол-Хятадын хамтарсан археологийн хээрийн шинжилгээний анги Хангайн нурууны баруун өмнөд хэсэгт орших Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт эртний түрэгийн үеийн 6 хүн чулуу, олон тахилын онгон шинээр илрүүлсэн билээ. Үүнээс гадна тухайн бүс нутагт урьд нь судалгааны эргэлтэд орсон 4 хүн чулууг нэмбэл нийт 10 хүн чулуу болно. Бид энэ 10 чулууны тодорхойлолт дээр дулдуйдаж бүс нутгийн онцлог, дүр дүрсэлбэр, он цагийн асуудлыг хөндлөө. Мөн уг хайгуул судалгааны үеэр түрэгийн руни бичгийн дурсгал, тамга тэмдэг бүхий дурсгалт газруудыг илрүүлж судалгааны эргэлтэд өмнө оруулсан юм. Руни бичгийн судалгааны дүнд эртний зам харилцааны газар бололтой гэж үзсэн. Мөн судлаачид Галуутын хүн чулуудаас холгүй Байдраг голын саваас илрүүлсэн бичээс, тамга тэмдгүүдийг судлаад эртний түрэгийн үеийн Басмыл аймгийн нутаг байж болох юм хэмээн таамаг дэвшүүлсэн байдаг. Ямартаа ч Галуут сумын нутагт буй хүн чулууд нь Түрэгийн хаант улсын сүүл үед хүчирхэгжсэн нь сурвалжид олонтой дурдагддаг Басмыл аймаг хийгээд түүний хөрш аймгуудыг түүхийг судлах сонирхолтой хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм.

Түлхүүр үг: Баянхонгор, Хүн чулуу, Галуут, Түрэгийн үе, Басмыл аймаг

Ankhubayar Batsuuri^{1✉}, Buyan-Orshikh Basandorj², Batbold Gonchig¹,
Bolorbat Tsendorj¹, Amgalantugs Tsend¹,
Cao Jianen³, Sun Guodong³, Caixi⁴, Caofeng³

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1,
Peace avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

²National Museum of Mongolia, Chingeltei district, Juulchin street-1,
Ulaanbaatar-15160, Mongolia

³Inner Mongolia Institute of Cultures Relics and Archaeology,
South Alley of Exhibition Hall, Xinhua street, Saihan district,
Inner Mongolian Autonomous Region, Huhehaote, R.P.China

⁴Institute for the History of Sciences and Technology,
Inner Mongolian Normal University, Zhaowuda Road,
Saihan district, Inner Mongolian Autonomous Region,
Huhehaote, R.P.China

Stone Statues in Galuut soum, Bayankhongor aimag

Abstract: During the 2018 and 2019 field seasons, the Mongolian-Chinese Joint Archaeological Expedition identified six previously unrecorded Old Turkic stone statues and numerous ritual enclosures in the territory of Galuut soum, Bayankhongor aimag, in the southwestern Khangai Mountains. Together with four stone statues previously documented from the same area, the total number of known examples in the region now stands at ten. Drawing on the descriptions of

these ten monuments, this article discusses their regional characteristics, iconographic features, and chronological. In the course of the same survey, several sites bearing Old Turkic runic inscriptions and tamga symbols were also identified and brought into scholarly discussion. Studies of these runic inscriptions suggest that the area may have been situated along an ancient route of communication. Moreover, based on the inscriptions and tamga symbols discovered in the Baidrag River basin, not far from the Galuut stone statues, some scholars have proposed that this region may once have belonged to the Basmil tribe during the Old Turkic period. In this regard, the stone statues of Galuut soum constitute valuable evidence for investigating the history of the Basmils-frequently mentioned in historical sources as a powerful tribe in the final period of the Turkic Khaganate-as well as that of their neighboring groups.

Keywords: *Bayankhongor, stone statue, Galuut, Turkic period, Basmil tribe*

Удиртгал

Төв Азийн өндөрлөгт хүн үүссэн эрт цагаас улбаалан нүүдлийн болон суурьшмал соёл иргэншилтэй олон үндэстэн угсаатан, овог аймаг, улс гүрэн үе улиран халагдаж солигдон аж төрсөөр ирснийг харуулах түүх, археологийн дурсгалууд нэн баялаг байдаг. Тэдгээрийн нэг бол МЭ VI-VII зууны хооронд өөрсдийн төрт улсыг Төв Азийн өндөрлөгт байгуулж Евроазийн хэмжээнд хүртэл өргөжүүлэн тэлж, мандан бадарч явсан Түрэг угсааны болон Түрэгийн бүрэлдэхүүнд байсан Монгол овог аймгууд юм. Дээрх овог аймгууд Евроазийн эх газрын ихэнх хэсгийг захирч суусан нь археологийн судалгаа болон түүхэн сурвалж бичгээс тодорхой харагддаг. Түрэгийн соёлын дурсгалуудын тархалтын цар хүрээ, нягтшил, дурсгалын овор хэмжээ зэрэг нь тухайн үеийн овог аймгуудын улс төрийн төв нь өнөөгийн Монгол улс тэр дундаа Алтай, Хангайн бүс нутаг байсан гэдгийг харуулах баримт болсон тэдний цогцлон байгуулсан хаад язгууртны цогцолбор дурсгал, тахилын онгон, хүн чулуу, булш оршуулга, хот суурин нь үүнийг илтгэнэ.

2018-2019 онд Монгол, Хятадын хамтарсан судалгааны анги Хангайн нурууны баруун өмнөд хэсэг Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг Цагаан Туруутын голын хөндийд археологийн хайгуул судалгаа хийж, 4 дурсгалт газар буй 6 хүн чулуу шинээр илрүүлж, нийт 8 хүн чулууны баримтжуулалт хийсэн юм (Анхбаяр нар 2018: 275). Эдгээр хүн чулууны дүр дүрсэлбэр, хийц загвар, тахилын онгоныг бусад бүс нутаг буй хүн чулуутай харьцуулж тус судалгааг хийв.

Судалгааны байдал

2008 онд Олон нуурын түрэгийн тахилын онгон, хүн чулууг профессор Д.Баяр нар судлан (Баяр нар 2014: 396) эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлснээр бидний хөндөн буй цаг үеийн судалгаа эхэлсэн гэж үзэж болно. Дараа нь Олон нуурын тахилын онгон, хүн чулуу, руни бичээс зэргийг судлаач Р. Мөнхтулга нар нийтэд хүргэсэн байна (Munkhtulga 2018: 15, Мөнхтулга 2018: 159; Баяр 2014: 404). 2018-2019 онд Монгол-Хятадын хамтарсан судалгааны анги Баянхонгор аймгийн

Галуут сумын нутаг Цагаан туруутын голын хөндийд археологийн хайгуул судалгаа хийж, 1000 гаруй дурсгал баримтжуулсан. Түүний дотор түрэгийн үед холбогдох хүн чулуу, тахилын онгон, руни бичээс, тамга тэмдэг зэргийг бүртгэн баримтжуулж, улмаар зарим өвөрмөц зохион байгуулалттай тахилын онгоныг малтан судалсан байна (Анхбаяр нар 2018: 275-276). Улмаар шинээр илрүүлсэн руни бичгийн дурсгалуудыг уншиж (Баттулга нар 2022: 45), зарим тамга тэмдгүүдийг (Батболд нар 2025:75) эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан байна.

Судалгааны арга зүй

Галуут сумын нутагт буй шинээр илрүүлсэн болон давтан судалсан хүн чулуудыг бид юуны өмнө археологийн судалгааны ерөнхий арга зүйн дагуу баримтжуулав. Дараа нь профессор Д.Баярын боловсруулсан хүн чулууг нарийвчлан тодорхойлох, ангилах, он цагийн баримжаа тогтоох арга зүйг ашиглав. Эцэст нь олдсон дурсгалуудыг өмнө судалгааны эргэлтэд орсон хүн чулууны судалгаатай харьцуулж, бүс нутагт хийгдсэн түрэгийн үеийн дурсгалуудын талаарх үзэл санаатай уялдуулж он цаг, эзэн холбогдогч зэргийг тогтоохыг зорилоо.

Дурсгалт газрын байршил, судалгааны эх хэрэглэгдэхүүн

Судалгааны эргэлтэд орж буй хүн чулуудын байршил нь Хангайн нурууны баруун өмнөд хэсэгт Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг Цагаан туруутын голын хөндий, Олгой нуурын сав, Сүмбэрийн голын хөндийд эртний нүүдэлчдийн адилаар өргөн хөндий, уулын бэл таг, голын дэнж, уулын тагт бүс зонхилно. Тухайн нутаг нь уул, ус тэгширсэн бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой ажээ (Зураг 1).

Төгрөгийн хүн чулуу. Галуут сумын төвөөс хойд зүгт Цагаан туруутын голын дээд биед Төгрөг хэмээх газар эрт цагт тоногдсон тахилын онгоны дэргэд нэгэн хүн чулуу босоо байдалтай байна. Хүн чулууг саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Бөмбөгөр оройтой малгай өмсөж, хөмсөг нүд, баруун зүүн хажууд чих гаргаж, баруун гараа

тохой хэсгээр хагас нугалан цээжиндээ аяга барьж, зүүн гараа тохой хэсгээр хагас нугалан бүснээс атгаснаар дүрсэлжээ. Зүүн урд зүгт чиглэсэн 13 ш зэл чулуу одоогоор мэдэгдэж байна (Зураг 2).

Шар хөндийн хүн чулууд. Галуут сумын төвөөс баруун хойд зүгт 15 орчим км зайд, Хонгор хайрхны баруун хойд талаас Цагаан туруутын голын сав руу чиглэсэн хөндийг Шар хөндий хэмээдэг. Тус хөндий нь түүх, археологийн дурсгалаар баялаг бөгөөд түүний дотор Түрэгийн хүн чулуу, тахилын онгонууд бий. Баруун хойд талд буй хүн чулууг 1-р хүн чулуу хэмээн дугаарлав (Зураг 3).

Шар хөндийн 1-р хүн чулуу: Энэхүү хүн чулуу нь дөрвөлжин хашлага чулуун дээр хээтэй тахилын онгоны дэргэд сул хэвтэж байх ба саарал өнгийн бүдүүн ширхэгтэй боржин чулуугаар хийсэн. Хүний толгой, их биеийн хэсгийг тодорхой гарган дүрсэлжээ. Баруун гараа тохой хэсгээр хагас нугалан цээжин хэсэгт сав барьж, зүүн гараа тохой хэсгээр хагас нугалан гарын алгыг сарвайлган хэвлий тус газраа барьсан байна. Дүрсэлбэрийн хувьд заримдаг дүрслэлтэй. Тахилын онгоны хашлага чулууны ирмэг хэсгээр гурвалжин гол хэсгээр хайрс маягийн хээ гаргасан байна. Тахилын онгон нь хавтан чулууны ирмэг хэсэгтээ гурвалжин дүрстэй бөгөөд түүнээс үргэлжлүүлэн загасны хайрс маягийн хээ гаргажээ.

Шар хөндийн 2-р хүн чулуу: 1-р хүн чулуунаас зүүн зүгт 200 м орчим зайд тоногдож эвдэгдсэн тахилын онгоны дэргэд сул хэвтэж байна. Хүн чулууг саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Толгой хэсэг хугарсан, толгойн нүүрэн хэсэгт монхор хамар, хувцасны гурвалжин захны ухлаадас, баруун гараа тохой хэсгээр нугалан цээжиндээ сав барьж, зүүн гараа тохой хэсгээр хагас нугалан цулгүй бүснээс гараа атгаснаар дүрсэлжээ.

Буянт голын хүн чулуу. Галуут сумын төвөөс хойд зүгт 10 км зайд Буянт голын хөндийд тахилын онгоны дэргэд босоо байдалтай нэгэн хүн чулуу байна. Хүн чулууг цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн. Хүний нүүр хэсгийг тусгайлан гаргаж, нумарсан хөмсөг, бүлтгэр нүд, шулуун монхор хамар, ам гарган дүрсэлжээ. Тахилын онгон 300 x 350 см хэмжээтэй (Зураг 4).

Сумын төвийн хүн чулуу. Галуут сумын төвд хүн чулуу бий. Хэзээ хэрхэн зөөвөрлөж ирсэн нь тодорхойгүй. Хүн чулууг цайвар саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Хүний толгой хэсгийг тусгайлан засаж, шулуун монхор хамар, зууван дугуй нүд, ам зэргийг дүрслэн гаргажээ (Зураг 5).

Олон нуурын хөндийн Чандманийн тасархайн хүн чулууд. Олон нуурын тахилын онгон нь Галуут сумын нутаг Олгой нуурын хөндий Чандманийн тасархай хэмээх газарт

байдаг бөгөөд язгууртны тахилын онгон юм. Түүний дэргэд 3 хүн чулуу байсан байна. 2008 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид малтлага судалгаа хийхдээ тэдгээрийн тухай нийтлүүлсэн байдаг (Мөнхтулга 2018: 158). Тус дурсгалт газраас 2 хүн чулууг Баянхонгор аймгийн Түүх, Угсаатны зүйн музей, 1 хүн чулууны тал хэсгийг Баянхонгор аймгийн Галуут сумын төв рүү тус тус зөөсөн байдаг. Харин тахилын онгоныг тонуулчид бусниулан хаяжээ. Тахилын онгон нь 4 тал хавтан чулуутай, хавтан бүрийн гадаргууг цэцэг ургамлын дүрс бүхий хээ угалзаар чимэглэсэн байна. Мөн нэг хавтан чулууны ирмэг хэсэгт руни бичээс байжээ.

Олон нуурын 1-р хүн чулуу: Тус хүн чулуу нь Галуут сумын төвд бий. Сумын төв дээр 2008-2009 оны үед хүн чулууны тал хэсгийг нь зөөвөрлөн авч ирсэн байна. Тус хүн чулуу нь саарал өнгийн боржин чулуугаар хийгдсэн. Хүн чулууны хоёр гар хугарч үгүй болсон байх ба баруун гараа цээжиндээ барьсан бололтой. Тус завиалан суусан хүний дүрслэл бүхий чулуу 2008 он гэхэд бүсэлхий хэсгээр хугархай байжээ (Мөнхтулга 2018: 161). Хөл хэсгийг нь тухайн үед сумын төв рүү зөөвөрлөхдөө орхисон бололтой (Зураг 6).

Олон нуурын 2-р хүн чулуу: Тус хүн чулуу нь Баянхонгор аймгийн Түүх, Угсаатны музейд хадгалагдаж байна. Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Толгой хэсэг хугарч үгүй болсон байх ба задгай гурвалжин энгэртэй хувцастай. Баруун талын энгэрийг зүүн талаар нь дарсан байдалтай дүрсэлжээ. Хоёр гараа тохой хэсгээр хагас нугалан цээжиндээ барьсан байдалтай. Хүн чулууг босоо байдалтай дүрсэлсэн бололтой (Зураг 7).

Олон нуурын 3-р хүн чулуу: Тус хүн чулуу нь Баянхонгор аймгийн Түүх, Угсаатны музейд хадгалагдаж байна. Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Толгой хэсэг нь хугарч үгүй болсон. Хоёр гараа тохой хэсгээр хагас нугалан урд талдаа том шавар сав бололтой зүйл дэмнэн барьжээ (Зураг 8).

Цагаан дэнжийн хүн чулууд. Галуут сумын нутаг Сүмбэрийн голын хөндийд Цагаан дэнж хэмээх газар 2 хүн чулуу байна.

Цагаан дэнжийн 1-р хүн чулуу: Эрт цагт тоногдож эвдэгдсэн тахилын онгоны дэргэд сул хэвтэнэ. Цайвар саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Хүн чулууны ихэнх хэсэг хугарч үгүй болсон, басхүү элэгдэлтэй тул дүр дүрслэлийн ихэнх хэсэг бүдгэрчээ. Ямартаа ч баруун гараа нугалан цээжиндээ хундага барьсан нь мэдэгдэнэ (Зураг 9).

Цагаан дэнжийн 2-р хүн чулуу: 1-р хүн чулууны зүүн талд гадна талаар усан татаал бүхий гол хэсэгтээ хээтэй хавтантай тахилын онгоны өмнө

сул хэвтэж байна. Толгой хэсэг нь хугарч үгүй болсон. Цайвар саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Баруун гараа тохой хэсгээр нугалан цээжиндээ барьж, бүсэлхий орчимд зүүн гараа

тохой хэсгээр хагас нугалснаар дүрсэлжээ. Усан татаалын хэмжээ 12 х 16 м бол тахилын онгон нь 360 х 350 см хэмжээтэй (Зураг 10).

Хүснэгт 1. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт буй хүн чулуудын дүрслэл, хэмжээ, байршил

№	Дурсгалт газрын байршил	Дүрслэл	Хэмжээ	GPS солбицол
1	Төгрөгийн хүн чулуу	Заримдаг	Өндөр 97 см, өргөн 60 см, зузаан 12 см	46°48'45.31" E100°01'38.53"
2	Шар хөндийн 1-р хүн чулуу	Заримдаг	Өндөр 150 см, өргөн 30 см	N46°45'11.09" E100°02'13.18"
3	Шар хөндийн 2-р хүн чулуу	Заримдаг	Өндөр 100 см, өргөн 40 см, зузаан 15 см	N46°45'15.09" E100°02'18.18"
4	Буянт голын хүн чулуу	Заримдаг	Өндөр 48 см, өргөн 30 см	N46°48'11.36" E100°07'41.13"
5	Сумын төвийн хүн чулуу	Заримдаг	Өндөр 62 см, өргөн 47 см	N46°42'04.75" E100°08'40.53"
6	Олон нуурын хөндий Чандманийн тасархайн 1-р хүн чулуу	Заримдаг	Өндөр 48 см, өргөн 53 см, зузаан 28 см	N46°35'02.86" E100°04'43.91"
7	Олон нуурын хөндий Чандманийн тасархайн 2-р хүн чулуу	Заримдаг	Өндөр 48 см, өргөн 53 см, зузаан 28 см	
8	Олон нуурын хөндий Чандманийн тасархайн 3-р хүн чулуу	Заримдаг	Өндөр 48 см, өргөн 53 см, зузаан 28 см	
9	Цагаан дэнжийн 1-р хүн чулуу	Заримдаг	Өндөр 35 см, өргөн 30 см, зузаан 26 см	N46°34'33.26"N
10	Цагаан дэнжийн 2-р хүн чулуу	Заримдаг	Өндөр 88 см, өргөн 51 см, зузаан 30 см	E100°22'35.58"

Харьцуулсан судалгаа

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт буй хүн чулууд нь заримдаг дүрслэлтэй байна. Заримдаг дүрслэл бүхий хүн чулууг судлаачид ийнхүү тодорхойлсон байдаг. “Заримдаг дүрслэл бүхий хүн чулууг хийхдээ биеийг бүтнээр нь дүрслэлгүй, ихэвчлэн зөвхөн толгой болон цээжин биеийг тодотгон дүрсэлжээ. Хүн чулууны нүүр амыг дүрслэхдээ ихэвчлэн товгор байдлаар урлах, мөн хагас товгор байдлаар зөвхөн нүүрэн талын гадаргууд нүүр, ам, эрхтний дүрс гаргаж цоолборлон, товойлгон дүрслэх арга зонхилох боловч зарим тохиолдолд нүүр хэсгийг зураасаар гаргасан нь ажиглагддаг” (Баяр 1999: 22; Төрбат нар 2009: 124; Буян-Орших 2024: 29).

Заримдаг дүрслэлтэй хүн чулуунууд Увс аймгийн нутагт 144 (Буян-Орших 2024: 29), Баян-Өлгий аймгийн нутагт 47 (Төрбат нар 2008: 126), Монголын төвийн бүс нутагт 35 (Баяр 1997: 28) бий. Энэ нь Түрэгийн хүн чулуу урлах аргын түгээмэл нэгэн хэлбэр бололтой. Тухайн бүс нутагт буй хүн чулууд нь бусад бүс нутагтай харьцуулан үзэхэд ижил төстэй байна. Дээрх хүн чулуудын дүрслэлбэрт малгай, бүс, сав суулга, дээл хувцас зэргийг дүрсэлжээ. Дүрслэлбэрт буй эдгээр зүйлсийг нарийвчлан хэлбэр хэмжээ, үүрэг зориулалт зэргийг нь тодорхойлж, бусад бүс нутагт буй хүн чулууд болон тухайн цаг үед холбогдох булш оршуулгын дурсгал зэрэгтэй харьцуулан үзэхэд тэдгээрийн он цаг, эдийн боловсролын хөгжил, улс хоорондын харилцаа,

овог аймгийн бүрэлдэхүүн, түүхэн газар зүй зэргийг тодорхойлон гаргах боломж бүрдэж байна.

Малгай. Төгрөгийн хүн чулуудад бөмбөгөр оройтой тоорцог (дуулга?) мэт малгай дүрсэлжээ. Хүн чулууны толгойн орой хэсгийг тусгайлан засаж мөлийлгөн хоёр нүдний дээд хэсэг хөндлөн зураас гаргасан байна. Энэ нь тухайн хүн чулууг малгайтай гэдгийг цохон харуулж буй хэлбэр юм. Энэ хэлбэрийн малгай Архангай аймгийн Хашаат сумын Шивээт толгой, Цэнхэр сумын Ар хоолой, Эрдэнэмандал сумын Цүүрийн гол, Булган аймаг Орхон сумын Ар хөндий, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Буурал (Монголын хүн чулуу 2016: 49, 69, 74, 135, 123), Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Могойтын ам, Баян-Өлгий аймгийн музей, Баян-Өлгий аймгийн эрчим хүчний хашаанд буй хүн чулуу (Баяр нар 1999: 37), Увс аймгийн нутагт 5 хүн чулуунд (Буян-Орших 2024: 48) тохиолдож байна. Бөмбөгөр оройтой тоорцог хэлбэрийн малгай нь Монгол болон хөрш зэргэлдээ бүс нутагт буй Түрэгийн үеийн хүн чулуудын дотор өргөн тархсан байдаг.

Дээл хувцас. Галуут сумын нутагт буй хүн чулуудын дотор энгэр заамыг тодорхой харуулсан дүрслэл 4 хүн чулуунд тохиолдоно. Тухайн бүс нутагт буй хүн чулуудын хүзүүний орчимд гурвалжлан тусгайлан зассан, хувцасны энгэр заамыг дүрсэлсэн нь тухайн хүн чулууг хувцастай гэдгийг харуулжээ. Энгэр заам гаргасан хүн чулуу Монголын төв нутагт 37 хүн чулуунд (Баяр 1997:

25), Монгол Алтайн бүс нутагт 65 хүн чулуунд (Баяр нар 1999: 35), Долоон усны сав газар 7 хүн чулуунд (Шер 1966: 30), Увс аймгийн нутагт 51 хүн чулуунд мэдэгдэж байна (Буян-Орших 2024: 48). Үүнээс Баянхонгор аймгийн Түүх, Угсаатан зүйн музейд хадгалагдаж буй Олон нуурын 2-р хүн чулууны хувцасны захыг зүүн гар талаас баруун тийш зөрүүлсэн байдлаар дүрсэлжээ. Энэхүү дүрслэлийг доктор Д.Баяр абугай “*Зүүн гар талаас баруун тийш дарж товчлох /зөв энгэртэй/*” хэмээн тодорхойлсон байдаг (Баяр 1997: 47). Зөв энгэртэй хувцас дүрслэл хүн чулуу төв Монголын нутагт 9 байна. Энэ нь Монгол улсын нутагт буй язгууртны тахилын онгоны дэргэд ганц нэгээр болон түүний цогцолборт хамаарагдаж байна. Үүнээс үзэхэд дээрх зөв энгэртэй дээл хувцас нь Түрэгийн язгууртны хүрээнд хэрэглэгддэг ёслол хүндэтгэлийн хувцас байж болох юм.

Сав суулга. Галуут сумын нутагт буй хүн чулуудын дотор 3 хүн чулуунд сав суулга, 1 хүн чулууны баруун гар цээжинд байгаа нь сав суулга барьсан байсныг харуулж буй бололтой. Тус сумын нутагт буй хүн чулуудад дүрсэлсэн сав суулга нь бусад бүс нутгийнхтай харьцуулан үзэхэд адил бол Чандманийн тасархайн 3-р хүн чулуу өвөрмөц дүрслэл бүхий сав суулга тэврэн сууж буй байдлаар дүрслэгджээ. Дээрх хэлбэрийн сав суулга тэврэн сууж буй байдлаар дүрсэлсэн хүн чулуу Өвөрхангай аймгийн Уянга сумын Онгийн цогцолбор (Баяр 1997: 93), Архангай аймгийн Хашаат сумын Хөшөө Цайдмын Культегиний тахилын онгон (Баяр 1997: 95), Номгоны тахилын онгон (Очир нар 2009: 35-47)-д тус тус дүрсэлжээ. Энэ нь утга агуулгын хувьд эзэн ноёндoo үйлчилж буй албат барлагийг дүрсэлж буй хэрэг бололтой (Зураг 11).

Хүн чулуунд янз бүрийн хэлбэртэй сав суулга бариулан дүрсэлдэг нь Евроазийн хээр талын бүс нутгийн аль ч хэсэгт нийтлэг тохиолддог, өргөн тархсан заншил агаад өргөлийн хоол ундыг хийж хэрэглэх сав (Сэр-Оджав 1970: 50) хэмээн үзжээ. Эртний нүүдэлчид үхэгсдэдээ зориулан булш оршуулгад сав суулга дагалдуулдаг нь эртний уламжлалтай агаад энэ нь Түрэгийн археологийн соёлд ч ажиглагдаж байна.

Бүс. Эртний нүүдэлчдийн хувцасны соёлын нэгэн чухал хэрэглэгдэхүүн бүс юм. Бүс нь тухайн үеийн уран дархны хөгжил, гоо зүйг илэрхийлэхээс гадна нийгмийн давхраажилт, гадаад харилцаа, бүс нутгийн онцлогийг харуулдаг. Түрэгийн үеийн хүн чулуунд нэгэн чухал элемент нь бүс юм. Хүн чулуунд бүсийг дүрслэхдээ дээл хувцаснаас илүүтэй янз бүрийн товруу чимэгтэй, агсарга унжлагатай, зэр зэвсэг агсаж, хавтага сав зүүсэн байдлаар дүрсэлсэн байдаг. Энэ нь тухайн үед бүс

чухал ач холбогдолтой байсныг илтгэнэ. Бидний судалгаанд хамруулсан хэрэглэгдэхүүний дотор Шар хөндийн хүн чулуудад л бүс дүрсэлжээ. Бүсийг дүрслэхдээ цулгуй буюу хос зураас гаргаж тухайн хүн чулууг бүстэй гэдгийг тодотгон харуулдаг.

Тахилын онгон. Эртний Түрэгүүд нас барагсдаа булшлан оршуулахын зэрэгцээ тэдний сүнснийг амарлиулж, хойд насандаа аз хийморьтой явахыг бэлгэдэн олноор цугларч тахил тайлгын зан үйл гүйцэтгэх онгон шүтээний газрыг тусад нь байгуулдаг байжээ. Түрэгийн тахилын онгоныг зохион байгуулалтын онцлогоор нь ерөнхийд эгэл жирийн болон язгууртны хэмээн 2 төрөлд хуваан авч үздэг. Үүнээс Галуут сумын нутагт буй хүн чулуудын 3 нь язгууртны тахилын онгонд, 4 нь жирийн иргэдийн тахилын онгонд хамаарч байна.

Монгол нутаг дахь Түрэгийн тахилын онгон нь тухайн нас барсан хүний язгуур угсаа, зэрэг дэвээс шалтгаалан их, бага янз бүрийн хэмжээтэй байхаас гадна бүтэц зохион байгуулалтаараа чулуун шороон далантай гэхчлэн энгийн даруугаас нүсэр том зэргээр эрс ялгаатай байдаг. Угсаа сурвалжит язгууртны онгоныг үйлдэхдээ, өнгөлж засаад хээ угалз гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага босгож үүний зүүн өмнө нь бодитой уран хийц бүхий хүн чулуу тавьж, олон зэл чулуу цувуулсан байдаг байна (Баяр 2007: 34). Олон нуурын тахилын онгоны 3 хашлага чулууны нүүрэн талыг цэцгэн хээгээр чимэглэж эдгээрийн цагариглан дугуйрсан шилбэтэй үзүүрт нь чандмань маягийн гурван дэлбээт цэцэг дүрсэлсэн ба энэ гурван цэцэг хоорондоо ишээрээ холбогджээ (Баяр 2014: 404). Мөн зүүн талын хашлага чулуу болон таг чулуун дээр 3 мөр руни бичээс (Зураг 13) бий (Munkhtulga 2008:117). Цагаан дэнжийн тахилын онгоны хашлага чулууны хойд талын чулуун дээр ирмэг хэсгээр хос шулуун зураас түүний дотор талд дугуйрсан цэцэг навчны дүрслэл гаргажээ.

Судлаачид тахилын онгонд дүрсэлсэн хээ угалзыг дүрсэлсэн байдлаар хэд хэдэн төрөлд хуваан үздэг (Battulga 2016: 232; Мөнхтулга 2019: 97). Түүний нэг нь цэцэг навч ургамлын дүрслэл юм. Ургамлын дүрслэлтэй хавтан чулуу Архангай аймаг Эрдэнэмандал Хөшөөн тал (Энхбат нар 2013: 109), Архангай аймаг Хашаат сум Хөшөө Цайдам (Munkhtulga 2016: 206), Тариат сум Шивэртийн ам (Войтов 2025: 51), Өвөрхангай аймаг Уянга Онгийн гол (Энхбат нар 2011:107), Булган аймаг Баян-Агт сум Зүүн түрүүний гол (Энхбат 2013: 52), Төв аймаг Эрдэнэ сум Тонькук (Войтов 2025: 44), Баянхонгор аймаг Баян-Овоо сум Талын улаан (Войтов 2025: 42), Төв аймаг Мөнгөнморьт Тогос уул (Эрэгзэн нар 2018: 45), Хэнтий аймаг Цэнхэрмандал Тавантолгой

(Энхбат нар 2010: 111), Архангай аймаг Хашаат сум Номгон 1 (Энхтөр нар 2024: 20), Дундговь Адаацаг (Цэлхагарав 2018: 24), Говьсүмбэр аймаг Сүмбэр сум Зараагийн үзүүр (Энхбат 2012: 26), Сүхбаатар аймаг Түвшинширээ сум Донгойн ширээ (Мөнхтулга 2019: 189) зэрэг дурсгалт газарт байна.

Руни бичээстэй тахилын хавтан чулуу Монгол улсын нутагт одоогийн байдлаар Архангай аймаг Эрдэнэмандал сумын Их Хануй нуур тахилын онгон (Баттулга 2022: 25), Булган аймаг Могод сумын Хөл Асгатын тахилын онгон (Монголын хүн чулуу 2016: 72), Архангай аймаг Цэцэрлэг сум Ажиргын бэлчрийн тахилын онгон (Мөнхтулга 2019: 98) зэрэг дурсгалт газар байна. Дээрх руни бичээс бүхий тахилын онгоны хавтан чулуу нь эртний Түрэгийн нийгмийн байгуулал угсаа гарвацийг тодруулахад чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

Шар хөндийн тахилын онгоны хашлага чулуунд загасны хайрс маягийн дүрслэл дүрсэлсэн байна. Хээг гаргахдаа ирмэг хэсгээр чоно маягийн хээ гаргаж түүний дотор талд загасны хайрс маягийн хээг үргэлжлүүлэн дүрсэлжээ. Түрэгийн тахилын онгоны хашлага чулуунд ийм хэлбэрийн хээ нь цөөн тохиолдоно. Өвөрхангай аймгийн Тарагт сумын Ноён талын тахилын онгонд (Энхбат нар 2011: 100) дүрсэлжээ (Зураг 12). Түрэгийн тахилын онгоны хашлага чулууны хээ угалзын утга агуулга нь тухайн дүрслэлээс хамаарч харилцан адилгүй байна.

Зэл чулуу. Түрэгийн тахилын онгоны салшгүй нэгэн бүрэлдэхүүн хэсэг нь зэл буюу “балбал” чулуу юм. Зэл чулууг Түрэгийн бараг бүх тахилын байгууламжид үйлдсэн байх бөгөөд тухайн талийгаачийн нийгэмд эзэлж байсан байр суурь, гүйцэтгэж байсан ажил үүрэг, нэр төрөөс шалтгаалаад овор хэмжээний хувьд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, хаад язгууртанд зориулан үйлдсэн тахилын байгууламжид зэл чулууг 552 хүртэлх тоотойгоор 200-2000 м зайд (Монголын түүх соёлын... 1999: 95), үйлдсэн байдаг бол жирийн иргэдийн тахилын онгонд 20-30 хүртэлх тоогоор 20-300 м зайд зэл чулууг босгосон байна. Галуут сумын нутагт буй Олон нуурын хүн чулууд, Төгрөгийн хүн чулуунд зэл чулуу дагалдуулсан байдаг. Зэл чулууг булш оршуулга хийгээд тахил тайлгын байгууламжид дагалдуулах уламжлалын тухайд хамгийн эртний зэл чулууг дурсгал нь Монгол улсын Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Хөшөөт хайрхан, Булгийн хяр, Долоон зэрэг газарт буй шоргоолжин булш (МЭӨ XIII-XI) бөгөөд баруун урагш чиглэсэн зэл чулуу дагалдуулжээ (Идэрхангай 2010: 189). Мөн Пазырык булш (МЭӨ V-III) (Төрбат нар 2009: 79), Увс аймгийн Давст сумын нутаг Урт бэлийн Чандмань-Сагирын булш (Батболд нар

2023:88), тахилын онгон булш оршуулгад зэл чулуу дагалдуулсан нь бий. Зэл чулууны утга агуулгын тухай эрдэмтэн судлаачид харилцан адилгүй санал дэвшүүлдэг.

Зэл чулууг түрүү хүрлийн үеэс эхлэн Төв Азийн өндөрлөгт буй эртний нүүдэлчдийн булш оршуулгад дагалдуулж, улмаар Түрэгүүд түүнийг авч өөрсдийн өвөрмөц хэв маягийг (тамга тэмдэг, руни бичээс) шингээн булш оршуулга тахил тайлгад ашиглах болсон. Нөгөө талаар тухайн талийгаачийн оршуулгад оролцсон үр хүүхэд, гэр бүл болон ойр дотнын хүмүүс болон захиргаанд байсан овгийн толгойлогчид зэл чулуу босгодог байсан байж болох юм. Үүнийг зэл чулуун дээр буй тамга тэмдэг, болон руни бичээс зэрэг нь харуулж байна. Хүн чулууны он цагийн хувьд Галуут сумын нутагт буй хүн чулуудын хийц загвар, дүр дүрслэл нь Түрэгийн үед хамаардаг. Үүнээс Цагаан дэнжийн 1-р хүн чулуу, Олон нуурын хүн чулууд, Шар хөндийн 1-р хүн чулууны тахилын онгоны бүтэц зохион байгуулалтаас үзэхэд судлаач В.Е.Войтовын гаргасан ангиллын 3-р хэлбэрт багтах ба энэ нь он цагийн хувьд VII зууны сүүлч VIII зууны эхэнд хамаарч байна.

Түүхэн газар зүйн тухайд Хангайн нурууны баруун урд хэсэг Түрэгийн үеийн аль аймгийн нутагт хамаарч байсан нь сурвалж судалгааны бүтээлээс үзэхэд тодорхой бус байдаг. Тухайн бүс нутагт эртний Түрэгийн булш оршуулга, тахилын онгон, тамга тэмдэг, руни бичээс зэрэг нь бусад бүс нутагтай харьцуулахад харьцангуй олон тохиолддог. Үүнээс үзэхэд Түрэгүүд тухайн бүс нутагт он удаан жилд нутагласан нь мэдэгдэж байна.

Дүгнэлт

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт буй 10 хүн чулууг баримтжуулан шинээр болон давтан судалгааны эргэлтэд орууллаа. Эдгээр хүн чулууны дийлэнх нь Цагаан туруутын голын савд бий. Галуут сумын нутагт буй хүн чулууд нь заримдаг дүрслэлтэй ажээ. Дүрсэлбэрийг бүс нутагт буй хүн чулуудтай харьцуулж үзвэл эртний Түрэгийн хүн чулуу урлах уламжлалын дагуу урласан болох нь тодорхой мэдэгдэнэ. Үүнээс зарим нэг дүрслэл нь онцлог ажээ. Тухайлбал, Олоннуурын 3-р хүн чулуу нь бохирон сууж, урдаа том суулга тэвэрсэн байдалтай байдаг. Ийм өвөрмөц дүрслэлтэй хүн чулуу Монгол нутагт буй томоохон язгууртны тахилын онгонд цөөн боловч тохиолддог. Утга агуулга нь эзэн ноёндoo үйлчилж буй албат барлагийг дүрсэлж буй бололтой. Он цагийн хувьд Цагаан дэнж 1-р хүн чулуу, Олон нуурын хүн чулууд, Шар хөндийн 1-р хүн чулуу нь VII зууны сүүлч VIII зууны эхэнд хамаарах боломжтой байна.

Түүнчлэн Цагаан туруу голын доод урсгал Байдраг голын савд буй Гурван Мандал уулын руни бичгийн дурсгал, Тайн нурууны Шивээт уулын руни бичгийн дурсгал, олон тамгат хөшөөг судалсан эрдэмтэд эртний түрэгийн Басмыл аймагтай холбоотой бөгөөд тэдний үндсэн нутаг болов уу хэмээн үзсэн байдаг. Энэ үеийн хятад сурвалжийн мэдээнд багагүй тэмдэглэгдсэн Басмыл аймаг нь Уйгур, Карлуктай хамтран 740-өөд оны үед Түрэг улсыг эсэргүүцэн босож мөхөөсөн юм. Иймээс Басмыл аймаг хийгээд тэдний хөрш түрэг аймгуудын түүх, соёлыг судлахад эдгээр хүн чулууд нэмэр болох нь дамжиггүй. Нөгөө талаар тухайн үед эдгээр хүн чулууг бидний археологийн судалгаа хийх зөвшөөрөлтэй Цагаан туруут голын сав буюу ирж буцах зам дагуу тун хязгаарлагдмал хүрээнд илрүүлсэн дурсгалууд болно. Тиймээс цаашид тухайн бүс нутагт ядаж сумын нутгийг бүхэлд нь хамруулж нарийвчилсан хайгуул судалгаа хийвэл илүү үр дүнд хүрэх боломжтой.

НОМ ЗҮЙ

Анхбаяр Б., Амгалантөгс Ц., Болорбат Ц., Батболд Г., Цао Жиан Эн, Сүн Гүо Дүн, Цао Пэн, Цай Си. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт явуулсан Монгол-Хятадын хамтарсан археологийн судалгааны 2018 оны ажлын тайлан. ШУА-ийн АХГБС. Улаанбаатар, 2018.

Баттулга Ц. *Монголын руни бичгийн шинэ судалгаа: Монголын умард, төвийн бүс нутаг дахь руни бичгийн дурсгал*. Улаанбаатар, 2022.

Батболд Г., Болорбат Ц., Амгалантөгс Ц., Лхүндэв Г., Дэлгэрмаа Г., Анхбаяр Б., Буян-Орших Б., Хишигпүрэв Г. Галуут сумын нутаг дахь Түрэг, Уйгурын үеийн тамга. // *Нүүдэлчдийн өв судлал*. Tomus XXVI, Fasc. 1-29, Улаанбаатар, 2025.

Батболд Н., Содномжамц Д., Цэлхагарав Ц., Түвшинжаргал Т., Чо Мина, Жион Жонвон,

Ким Юннюн, Сео Канмин. Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг хамгаалах” төслийн хүрээнд Увс аймгийн Давст сумын Урт бэлийн дурсгалт газар хийсэн археологийн судалгааны ажлын үр дүн // *Монголын археологи-2023*. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2023.

Баяр Д. *Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу*. Улаанбаатар, 1997.

Баяр Д., Эрдэнэбаатар Д. *Монгол Алтайн хүн чулуун хөшөө*. Улаанбаатар, 1999.

Баяр Д. “Түрэгийн үеийн тахилын онгон хүн чулууг судлан шинжилсэн нь” // *Монголын археологийн шинжлэх ухаан. Монгол Улсын Шинжлэх Ухаан, 32-р боть*, Улаанбаатар, 2007: 80-115.

Буян-Орших Б. *Увс аймгийн нутаг дахь хүн чулууны судалгаа (VI-IX зуун)*. Улаанбаатар, 2024.

Войтов В.Е. *VI-VIII зууны Монголын тахил-тайлгын дурсгалууд дахь Эртний Түрэгийн онгон ба орчлон ертөнцийн загвар*. Орч. С.Өлзийбаяр, Ц.Төрбат, Улаанбаатар, 2025.

Идэрхангай Т. Монгол нутаг дахь “Зэл чулуут” дурсгалын тухайд. // *Studia Archaeologica*. Tom (IX) XXIX, Fasc 11. Улаанбаатар, 2010.

Мөнхтулга Р. Эртний Түрэгийн язгууртны тахилын онгоны судалгааны зарим асуудлууд. Түүхийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, 2019.

Мөнхтулга Р. Олон нуурын хөндийн дурсгал. *Түрэг, монгол судлалын өгүүллүүд. Эрдэм шинжилгээний бүтээлийн түүвэр (2003-2018)*. Улаанбаатар, 2018.

Мөнхтулга Р. A report on the newly found memorial inscriptions from Olon nuur valley. *Түрэг, монгол судлалын өгүүллүүд. Эрдэм шинжилгээний бүтээлийн түүвэр (2003-2018)*. Улаанбаатар, 2018.

Монголын хүн чулуу. *Монголын археологийн өв боть-5*. Эрхлэн хэвлүүлсэн Амартүвшин Ч., Бадма-Оюу Б. Улаанбаатар, 2016.

Монголын түүх соёлын дурсгал сэдэвчилсэн лавлах. Улаанбаатар, 1999.

Сэр-Оджав Н. *Эртний Түрэгүүд (VI-VIII зуун)*. Улаанбаатар 1970.

Очир А., Одбаатар Ц., Эрдэнэболд Л., Анхбаяр Б. Номгоны түрэг дурсгалууд. *Нүүдэл судлал сэтгүүл*. Улаанбаатар, 2009.

Төрбат Ц., Баяр Д., Цэвээндорж Д., Баттулга Ц., Баярхүү Н., Идэрхангай Т., Жискара П.Х., *Монгол Алтайн археологийн дурсгалууд-I: Баян-Өлгий аймаг*. Улаанбаатар, 2009.

Цэлхагарав Ц. Адаацаг сумын түүх, соёлын дурсгал. Улаанбаатар, 2018.

Шер Я.А. *Каменные изваяние Семиречья*. Москва, 1966.

Энхбат Г., Даваацэрэн Г. *Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал-Хэнтий аймаг*. I дэвтэр. Улаанбаатар, 2010.

Энхбат Г., Даваацэрэн Г., Пүрэвхам Л. *Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал-Өвөрхангай аймаг*. V дэвтэр. Улаанбаатар, 2010.

Энхбат Г., Даваацэрэн Г. *Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал-Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймаг*. VII дэвтэр. Улаанбаатар, 2012.

Энхбат Г., Даваацэрэн Б., Болд Р. Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал. Булган аймаг. VIII дэвтэр. Улаанбаатар, 2012.

Энхбат Г., Анхсанаа Г., Даваацэрэн Б. *Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал. Архангай аймаг*. X дэвтэр. Улаанбаатар, 2013.

Энхтөр А., Буянхишиг Ц., Батболд Г., Барс М., Напил Б., Нурболот Б. Монгол-Олон улсын Түрэг академийн хамтарсан “Номгон” төслийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар, 2024.

Эрэгзэн Г., Усэй Ён., Ким Жин Гён., Алдармөнх П., Энхболд С., Ким Сан мин, Хуан Бо Чансо. Гуа довын Хүннүгийн дурсгал. Улаанбаатар, 2018.

Battulga Ts. On the Ancient Turkic arts of stone. // *Turkic foot prints in Mongolia*. Ulaanbaatar, 2023.

REFERENCES

Ankhubayar B., Amgalantugs Ts., Bolorbat Ts., Batbold G., Tsao Jian En., Sun Guodun., Tsao Pen., Tsai Si. Bayankhongor aimgiin Galuut sumyn nutagt ywuulsan Mongol-Khyatadyn khamtarsan arkheologiin sudalgaany 2018 ony tailan. // SHUA-iin AKHGBC. Ulaanbaatar, 2018.

Battulga Ts. Mongolyn runi bichgiin shine sudalгаа: Mongolyn umard, tuviin bus nutag dakhi runi bichgiin dursгал. Ulaanbaatar, 2022.

Battulga Ts. On the Ancient Turkic arts of stone. // *Turkic foot prints in Mongolia*. Ulaanbaatar, 2023.

Batbold G., Bolorbat Ts., Amgalantugs Ts., Lhunde G., Delgermaa G., Ankhubayar B., Buyan-Orshikh B., Khishigpurev G. Galuut sumyn nutag dakhi Tureg, Uiguriin tamga. // Nuudelchdiin uv sudlal. Tomus XXVI, Fasc. 1-29. Ulaanbaatar, 2025.

Batbold N., Sodnomjamts D., Tselkhagarav Ts., Tuvshinjargal T., Cho Mina., Jion Jonwon., Kim Yunnyn, Ceo Kanmin. Mongol-Solongosyn khamtarsan “Soyoliin uviig khamgaalakh” tusliin khureend Uvs aimgiin Davst sumyn Urt beliin dursгалt gazar khiisen arkheologiin sudalgaany ajlyn ur dun. // *Mongolyn arkheologi-2023*. Erdem shinjilgeenii khurlyn emkhetgel. Ulaanbaatar, 2023.

Bayar D., Erdenebaatar D. Mongol Altain khun chuluun khushuu. Ulaanbaatar, 1999.

Bayar D. Turegiin uyeiin takhiliin ongon khun chuluug sudlan shinjilsen ni. Mongol Ulsyn Shinjlekh Ukhaan. 32-r boti. Mongolyn arkheologiin shinjlekh ukhaan. Ulaanbaatar, 2007.

Buyan-Orshikh B. Uvs aimgiin nutag dakhi khun chuluuny sudalгаа (VI-IX zuun). Ulaanbaatar, 2024.

Boitov.B.E. VI-VIII zuuny Mongolyn takhil-tailgyn dursгалууд dakhi Ertnii Turegiin ongon ba orchlon ertuntsiin zagvar. Orchuulsan: S.Ulziibayar. Ts.Turbat. Ulaanbaatar, 2025.

Iderkhangai, T. Mongol nutag dakhi “Zel chuluut” dursгалын tukhaid. // *Studia Archaeologica*.

Tom. (IX) XXIX, Fasc. 11, Ulaanbaatar, 2010.

Munkhtulga R., Ertnii Turegiin yazguurny takhilyn ongony sudalgaany zarim asuudluud. Tuukhiin ukhaany doktoryn zereg gorilson buteel. Ulaanbaatar, 2019.

Munkhtulga R. Tureg, mongol sudlалyn oguuleluud. Erdem shinjilgeenii buteeliin tuuver (2003-2018). Ulaanbaatar, 2018.

Mongolyn khun chuluu. Mongolyn arkheologiin uv. boti-5. Erkhlen khevuulsen Ch. Amartuvshin, B.Badma-Oyu. Ulaanbaatar, 2016.

Mongoliin tuukh soyolyn dursгал sedevchilsen lavlakh. Ulaanbaatar, 1999.

Ser-Odjav N. *Ertnii Tureguud (VI-VII zuun)*. Ulaanbaatar, 1970.

Ochir A., Odbaatar Ts., Erdenebold L., Ankhubayar B. Nomgony Tureg dursгалууд. Nuudel suudal setguul. Ulaanbaatar, 2009.

Turbat Ts., Bayar D., Tseveendorj D., Battulga Ts., Bayarkhuu N., Iderkhangai T., Jiskar P.Kh. Mongol Altain arkheologiin dursгалууд-I. Bayan-Ulgii aimag. Ulaanbaatar, 2009.

Tselkhagarav Ts. Adaatsag sumiin tuukh soyoliin dursгал. Ulaanbaatar, 2018.

Sher Y.A., Kaminnie izvaynie Semirechiy. Moskva, 1966.

Enkhubat G., Davaatseren G. Mongol nutag dakhi tuukh soyoliin ul khudlukh dursгал-Khentii aimag I devter. Ulaanbaatar, 2010.

Enkhubat, G., Davaatseren G., Purevlham L. Mongol nutag dakhi tuukh soyoliin ul khudlukh dursгал-Uvurkhangai aimag. V devter. Ulaanbaatar, 2010.

Enkhubat G., Davaatseren G. Mongol nutag dakhi tuukh soyolyn ul khudlukh dursгал- Govisumber, Darkhan-Uul, Orkhon aimag. VII devter. Ulaanbaatar, 2012.

Enkhubat G., Davaatseren G., Bold R. Mongol nutag dakhi tuukh soyolyn ul khudlukh dursгал-Bulgan aimag. VIII devter. Ulaanbaatar, 2012.

Enkhubat G., Ankhsanaa G., Davaatseren G. Mongol nutag dakhi tuukh soyolyn ul khudlukh dursгал-Arkhangai aimag. X devter. Ulaanbaatar, 2013.

Enkhtur A., Buyankhishig Ts., Batbold G., Bars M., Napil B., Nurbolot B. Mongol-Olon ulsyn Tureg akademiin khamtarsan “Nomgon” tusliin kheeriin shinjilgeenii ajlyn tailan. Ulaanbaatar, 2024.


Eregzen G., U Sei Yon, Kim Jin Geon, Aldarmunkh P., Enkhbold S., Kim San Min, Khuan Bo Chanso. Gua doviin Khunnugiin dursгал. Ulaanbaatar, 2018.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>


Хавсралт зураг




Зураг 1. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт буй хүн чулуудын тархалтын дэвсгэр зураг




Зураг 2. Төгрөгийн хүн чулуу (гар зургийг Д.Амараа)




Зураг 3. Шар хөндийн 1,2-р хүн чулуу (гар зургийг Б.Буян-Орших)




Зураг 4.Буянт голын хүн чулуу (гар зургийг Б.Буян-Орших)




Зураг 5. Галуут сумын төвийн хүн чулуу (гар зургийг Б.Буян-Орших)



Зураг 6. Чандманийн тасархайн 1-р хүн чулуу (гар зургийг Б.Буян-Орших)




Зураг 7. Чандманийн тасархайн 2-р хүн чулуу (гар зургийг Б.Буян-Орших)




Зураг 8. Чандманийн тасархайн 3-р хүн чулуу (гар зургийг Б.Буян-Орших)




Зураг 9. Цагаан дэнжийн 1-р хүн чулууны гар болон гэрэл зураг



Зураг 10. Цагаан дэнжийн 2-р хүн чулуу (гар зургийг Б.Буян-Орших)



1.



2.

Зураг 11. Монгол нутаг дахь том вааран сав тэвэрсэн хүн чулууд. 1-Баянхонгор аймаг Галуут сум Олоннуурын 3-р хүн чулуу, 2-Өвөрхангай аймаг Уянга сум Онгийн гол (Баяр Д., 1997)




1.




2.

Зураг 12. Түрэгийн тахилын онгоны хавтан чулуун дээрх хээ. 1. Баянхонгор аймгийн Галуут сум Шар хөндий. 2. Өвөрхангай аймаг Тарагт сум Ноён тал (Соёлын өвийн төв 2011)



1.



2.

Зураг 13. 1. Олон нуурын тахилын онгоны хавтан чулуу (Munkhtulga R., 2008), 2. Улаанбаатар хот, Налайх. Тоньюкукын тахилын онгоны хавтан чулуу (Баяр Д., 1989)